




# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТ 20 ЖИЛ



Эрчим хүчний зохицуулах  
хорооны Зохицуулагч  
Э.Түвшинчулуун

Улаанбаатар хот  
2021.11.17




- 1 | Эрчим хүчний зохицуулах хороо, зохицуулалтын эрх зүйн орчин
- 2 | Эрчим хүчний зохицуулалтын онцлох ажлуудаас
- 3 | Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн зохицуулалт
- 4 | Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт
- 5 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хэрэгжилт
- 6 | Эрчим хүчний зохицуулах хорооны хөгжлийн стратеги


# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРОО БАЙГУУЛАГДСАН ШИЙДВЭРҮҮД

**2001.02.01** — Эрчим хүчний салбарын төвлөрсөн тогтолцоог өөрчилж бие даасан компаниудын хэлбэрт шилжүүлсний зэрэгцээ олон улсын жишигт нийцсэн, төрийн зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилго бүхий биеэ даасан, хараат бус Зохицуулах байгууллагыг байгуулж ажилласан явдал нь эрчим хүчний үнэ тарифыг бодитой тогтоох, үйлдвэрлэлийн найдвартай ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалахад ихээхэн ач холбогдолтой болсон.

**2001.04.16** — Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн 83 дугаар тогтоолоор Эрчим хүчний зохицуулах газрыг байгуулж, дүрмийг батлав.



**2001.06.29** — Дэд бүтцийн сайдын 2001 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 188 дугаар тушаалаар Эрчим хүчний зохицуулах газрын Удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, цалингийн санг тогтоон үйл ажиллагааг нь эхлүүлэв.



**Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль**  
Шинээр батлагдав.

**Эрчим хүчний тухай хууль**  
(нэмэлт, өөрчлөлт)

- Дэмжих тариф
- Бие даасан үйлдвэрлэгчтэй худалдах худалдан авах гэрээ байгуулах, уг үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнийг батлах.
- Хийн хангамжийг зохицуулах.

**Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль**

Шинээр батлагдав.

**Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль** (нэмэлт, өөрчлөлт)

- Төслийг өрсөлдөөнт үнэ хаялцуулах зарчмаар Эрчим хүний яамнаас сонгон шалгаруулдаг тогтолцоонд шилжүүлсэн.
- Нар, салхины эрчим хүчний тарифын дээд хязгаарыг тогтоож өгсөн.
- Айл өрх, албан байгууллагууд өөрийн хэрэглээнээс илүү гарсан цахилгааны түгээх сүлжээнд худалдах боломжийг бий болгосон.

2001

**Эрчим хүчний тухай хууль**  
Шинээр батлагдав.

2007

2011

**Эрчим хүчний тухай хууль**  
(нэмэлт, өөрчлөлт)

- Зохицуулагчдын зөвлөлд хэрэглэгчдийн төлөөллийг буюу Худалдаа, аж үйлдвэрийн танхим, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн саналаар 2 зохицуулагчийг томилдог болсон.
- Эрчим хүчний зохицуулах хороо нь зохицуулалтын үйлчилгээний хөлс болон төсвөө өөрсдөө баталдаг тогтолцоонд шилжсэн.
- Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүд орон тооны 1 гишүүнтэй болсон.
- Түлшний үнийг хянах болсон.

2015

**Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль**

Шинээр батлагдав.

2015

**Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль** (нэмэлт, өөрчлөлт)

- “дэмжих тариф” гэж сэргээгдэх эрчим хүчийг дэмжих зорилгоор эрчим хүчний үнэд шингээсэн тарифыг”,
- “хэрэглэгчийн худалдан авах дэмжих тарифын хэмжээг тогтоох”,
- “Энэ хуулийн 11.1-д заасан үүсгүүрээр үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчний үнийн зөрүүг **дэмжих тарифаар** нөхөн олгоно” гэж тус тус заасан.


2019

➤ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТАЛААР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” 2010 ОНЫ 72 ДУГААР ТОГТООЛ;

➤ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ “ТҮЛШ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ” ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТУХАЙ 2015 ОНЫ 2 ДУГААР ТОГТООЛ;

➤ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН “ТӨРӨӨС ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО /2015-2030/” 2015 ОНЫ 63 ДУГААР ТОГТООЛ;

Эдгээр тогтоолын хүрээнд тодорхой ажлуудыг хэрэгжүүлснээр салбарын урт хугацаат зээлийн өрийн дарамт багассан, компани хоорондын өр авлага, өртөг зардал буурсан, томоохон шинэчлэлийн ажлуудыг улсын төсвөөс санхүүжүүлсэн, эрчим хүчний үнэ тарифыг бодит өртгөөр тооцох, чадлын тариф, ногоон тариф нэвтрүүлэх, холболтын төлбөрийн тогтолцоог бий болгох зэрэг салбарын хувьд нааштай үр дүнд үрсэн.



хуульд заасны дагуу хувийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах хувилбаруудыг судлан аль оновчтойг нь сонгох замаар техник, технологийн шинэчлэл хийх, боловсон хүчин, цалин хөлс, үнэ тарифын нэгдсэн бодлогоор хангах асуудлыг шийдвэрлэх;

6/эрчим хүчний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, өртөг, зардлыг хямдруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилгоор эрчим хүчний шинэ эх үүсвэрийг Багануур болон бусад нүүрсний уурхайг түшиглэн барьж байгуулах, Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж байгаа цахилгаан, дулааны хэрэгцээг 3, 4 дүгээр цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх, өргөтгөн шинэчлэх замаар шийдвэрлэх;

7/улсын төсвөөс татаас олгож байгаа хугацаанд ахуйн цахилгааны үнэ, тарифыг шатлалтай болгон өрх бүрийн сарын хэрэглээний 150 кВт-ийг одоогийн мөрдөж байгаа үнэ тарифыг индексжүүлэн тооцож, түүнээс дээшхи хэрэглээ болон үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын эрчим хүчний үнэ, тарифыг бодит өртгөөр тооцох, үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад чадлын тариф нэвтрүүлэх;

8/эрчим хүчний салбарын компаниудыг 2014 оноос эхлэн Эрчим хүчний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, 26.2.5-д заасны дагуу зах зээлийн зарчимд шилжүүлэн ажиллуулах бодлого, зохион байгуулалтын арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран авч хэрэгжүүлэх;

9/Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан түгээх сүлжээг бүрэн шинэчилж, өвлийн улиралд шөнийн цагаар ахуйн цахилгааны хэрэглээний үнэ, тарифыг "0" төгрөгт шилжүүлэх талаар бодлого боловсруулах.

2.Энэ тогтоолын хэрэгжилтийн явцын талаар жил бүрийн 4 дүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монгол Улсын Засгийн газар /С.Батболд/-т, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Ц.Баярсайхан/-нд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ



2

Эрчим хүчний зохицуулалтын онцлох ажлуудаас

### “Нэг худалдан авагч”-тай загвар

Дэд бүтцийн сайдын “Загвар батлах тухай” 240 дүгээр тушаалаар батлагдав.

2002

### Төв ба Зүүн Европын орнуудын эрчим хүчний зохицуулах байгууллагуудын нийгэмлэг (ERRA)

Монгол Улсын Эрчим хүчний зохицуулах жинхэнэ гишүүнээр элсүүлж баталсан.

2003

### АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)

хамтран ажиллах хоёр дахь шатны Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав.

2004

### Цахилгаан, дулааны үнэ тарифын талаар олон нийтийн хэлэлцүүлэг

Улаанбаатар хот, Налайх дүүрэг, Дорнод аймагт зохион байгуулав.

### Зүүн Ази ба Номхон далайн орнуудын Зохицуулах байгууллага (EAPIRF)

Жинхэнэ гишүүнээр элсэв.

2005

### Цахилгааны “СПОТ” зах зээл

Төвийн бүсийн үйлдвэрлэгчдийн хүрээнд хэрэгжүүлж эхлэв.

2006

### Дансны нэгдсэн жагсаалт

Эрчим хүчний салбарт хэрэгжүүлж эхлэв.

### Урамшуулалт зохицуулалтын нэг хэлбэр “Гүйцэтгэлийн гэрээ”

Тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудтай байгуулж эхлэв.

### Өрсөлдөөнт (аукционы) зах зээл

Төвийн бүсийн цахилгаан үйлдвэрлэгчдийн дунд хэрэглээний өсөлтөд суурилсан өрсөлдөөнт зах зээлийг ажиллуулж эхлэв.

2007

### Азийн хөгжлийн банктай хамтран Төв Азийн орнуудын эрчим хүчний зохицуулах байгууллагуудын III хуралдаан

Улаанбаатар хотноо зохион байгуулав.

### Дөргөний усан цахилгаан станц

Зохицуулагчдын зөвлөлийн тогтоолоор тус станцын цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгож, тарифыг тогтоов.

2008

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОХ АЖЛУУДААС

2009

### “Сэргээгдэх эрчим хүчний зохицуулалтын хөгжлийн төлөвлөгөө”

Монгол Улсын сэргээгдэх эрчим хүчний салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн зохицуулалт бий болгох зорилгоор Европын сэргээн босголт хөгжлийн банктэй хамтран боловсруулав.

2010

### Тайширын усан цахилгаан станц

Зохицуулагчдын зөвлөлийн тогтоолоор тус станцын цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг олгож, тарифыг тогтоов.

2011

### Эрчим хүчний салбарын урт хугацаат зээлийг анх зээлсэн үеийн ханшаар тооцон төгрөгт шилжүүлэх

Тайлан тэнцэлд тусгадаг болов.

2012

### Эрчим хүчний зохицуулах хороо

Монгол Улсын Засгийн газрын 49 дүгээр тогтоолоор өөрчлөн зохион байгуулагдав.

2013

### “Тарифын зохицуулалтын бус төлбөрт үйлчилгээний журам”

Эрчим хүчний зохицуулах хорооны 2013 оны 150 дугаар тогтоолоор анх удаа баталж, монопол зах зээл дээр хийгддэг зарим төрлийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг Эрчим хүчний зохицуулах хорооноос хянадаг болов.

### Эрчим хүчний зохицуулах хорооны барилгын өргөтгөл

ашиглалтад оруулав.

2014

### E-License цахим систем

Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага тогтоох, үнэлэх журмыг баталж гаргасны зэрэгцээ тусгай зөвшөөрлийн өргөдөл хүлээн авах цахим системийг нэвтрүүлэв.

### Эрчим хүчний үнэ тарифыг индексжүүлэх журам

Шинээр батлав.

2015

### “Цахилгаан худалдах, худалдан авах гэрээний загвар”, “Бие даасан эрчим хүч үйлдвэрлэгчийн гэрээний гарааны үнэ тогтоох аргачлал”

Эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилтын хүрээнд

### Эрчим хүч хэмнэлтийн нэгж

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны хоёрдугаар сарын 29-ний өдрийн 132 дугаар тогтоолоор Хорооны бүтцэд шинээр байгуулав.

### Үүрэг хүлээсэн хэрэглэгч

Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 232 дугаар тогтоолоор 127 аж ахуйн нэгж байгууллагыг тодорхойлж, бүртгэв.

### Монгол Улсад анхны Эрчим хүчний аудитор

Сургаж бэлтгэн гэрчилгээг олгов.

### Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн бүсчилсэн зөвлөгөөн

Бүсчилсэн Дорнод, Ховд, Эрдэнэт, Улаанбаатар хотод уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулав.

### Эрчим хүч хэмнэх Үндэсний хөтөлбөр

Монгол улсын Засгийн газрын 2017 оны есдүгээр сарын 20-ны өдрийн 274 дүгээр тогтоолоор хөтөлбөрийг батлуулав.

### “Урамшуулалт зохицуулалтын журам” “Цахилгааны өрсөлдөөнт зах зээлийн дүрэм”

Баталж мөрдүүлэв.

### Улаанбаатар хотын хэмжээнд дулаан түгээх, хангах үйл ажиллагааг хуульд нийцүүлэх

Улаанбаатар хотын хэмжээнд дулааны эрчим хүчний гэрээт борлуулагч нэртэй **530** гаруй хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоож, **66** тусгай зөвшөөрөл эзэмшигч болгон, үнэ тарифыг баталж өгснөөр хэрэглэгчдийн эрх ашиг хуулиар хамгаалагдах болсон.

2016

## ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОХ АЖЛУУДААС

2017

2018

### Орон нутгийн дулаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уулзалт - зөвлөгөөн

Эрчим хүчний зохицуулах хорооноос зохион байгуулав.

### Ногоон санхүүжилтийн чуулган

Хас банктай хамтран зохион байгуулав.

### Эрчим хүчний зохицуулах хорооны стратегийн баримт бичиг (2018-2021 он)

Боловсруулан хэрэгжүүлж эхлэв.

### “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн нийт 110.8 тэрбум төгрөгийн өр

“Засгийн газрын 2018 оны 132 дугаар тогтоолоор тус өрийг тухайн нүүрсний уурхайд оруулсан хөрөнгө оруулалт болгон тооцохоор шийдвэрлүүлэв.

### “Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн нэгдсэн зөвлөгөөн”

Зохион байгуулав.

### Эрчим хүчний зохицуулах хорооны эрчим хүчний хэмнэлттэй оффисын байр

Ашиглалтад оров.

2019

### Дулааны дөрөвдүгээр цахилгаан станцын 1-4 дүгээр турбоагрегатын шинэчлэл, өргөтгөл

Эрчим хүчний зохицуулах хорооноос зээлийн баталгаа гаргах, зээлийн хүүгийн төлбөрийг тарифт тусгах шийдвэрүүдийг гаргаж дэмжлэг үзүүлж ажиллав

2020

### Нар, салхины эрчим хүчний 9 эх үүсгүүр

Эх үүсгүүрүүд ашиглалтад орсонтой холбогдуулан цахилгаан үйлдвэрлэх тусгай зөвшөөрлүүдийг олгох, сэргээгдэх эрчим хүчийг дэмжих тарифыг батлах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэв.

2013-2020





### 3 | Эрчим хүчний тусгай зөвшөөрлийн зохицуулалт

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН БОЛОН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ТОО

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	2001 он		2006 он		2011 он		2016 он		2020 он		2021 он	
		Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо	Тусгай зөвшөөрлийн тоо	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоо
1	Уламжлалт эх үүсгүүр	7	7	7	7	7	7	8	8	11	9	11	9
	Цахилгаан үйлдвэрлэх Сэргээгдэх эх үүсгүүр					6	6	5	5	13	13	13	13
	<b>Дүн</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>7</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>13</b>	<b>24</b>	<b>22</b>	<b>23</b>	<b>21</b>
2	Дулаан үйлдвэрлэх	8	1	10	3	10	3	22	14	27	20	27	20
3	Цахилгаан дамжуулах	2	2	2	2	2	2	3	2	3	2	3	2
4	Цахилгаан түгээх, хангах	25	9	34	13	39	16	54	20	62	25	64	26
5	Дулаан түгээх, хангах	16	3	65	25	77	29	65	14	191	73	191	73
6	Диспетчерийн зохицуулалт	1	1	1	1	1	1	1	1	1	1	1	1
7	Цахилгаан импортлох, экспортлох	3	0	11	6	16	8	13	3	9	1	9	1
8	Уламжлалт эх үүсгүүр			3	2	7	5	22	18	18	15	16	13
	Эрчим хүчний барилга			1	1	6	6	23	23	31	30	25	23
	байгууламж барих					1		2	0	4		4	1
	Шугам сүлжээ, дэд станц					1		8	5	3	3	2	2
	Дулааны станц					1		8	5	3	3	2	2
	<b>Дүн</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>15</b>	<b>11</b>	<b>55</b>	<b>46</b>	<b>56</b>	<b>48</b>	<b>47</b>	<b>39</b>
<b>Дүн</b>		<b>62</b>	<b>23</b>	<b>134</b>	<b>60</b>	<b>173</b>	<b>83</b>	<b>226</b>	<b>113</b>	<b>373</b>	<b>192</b>	<b>365</b>	<b>183</b>

## 2001 онд:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд **23**

Хувийн өмчит хуулийн этгээд

Нийт **23**



## 2021 онд:

Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд **44**

Хувийн өмчит хуулийн этгээд **139**

Нийт **183**



## Өсөлт


**21**

**139**

**160**

## Дотоод хэрэгцээний цахилгааны хувь хэмжээний зорилтот түвшний судалгаа

Нийт хэмнэлт **353.1** сая кВтц



Эрчим хүчний зохицуулах хорооноос жил бүр дотоод хэрэгцээний цахилгаан эрчим хүчний хувь хэмжээнд зорилт тогтоож, биелэлтэд хяналт тавин ажиллаж ирсэн эрчим хүч үйлдвэрлэхэд зарцуулах цахилгааны хувь хэмжээ **7.84 нэгжээр** буурснаар **353.1 сая кВт.ц** цахилгаан хэмнэж борлуулалтаа нэмэгдүүлжээ.

## ТБНС-ний цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын судалгаа

Нийт хэмнэлт **428.2** сая кВтц



Эрчим хүчний зохицуулах хорооноос цахилгаан дамжуулалт, түгээлтийн алдагдлын хувь хэмжээг жил бүр тогтоож, хяналт тавьж ажилласнаар Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний хэмжээнд 2002 онд **23.0 хувь** байсан бол 2020 оны гүйцэтгэлээр **13.6 хувьд** хүрсэн.

Энэ хугацаанд нийт **428.2 сая кВт.ц** цахилгаан эрчим хүч хэмнэсэн ба үүнийг дундаж үнээр тооцвол **32.2** тэрбум төгрөгийг хэмнэсэн үр дүнтэй байна.

Түгээлтийн алдагдлыг нийт дүнгээр баталж байсныг 2019 оноос эхлэн шинийн борлуулалтаас салгаж тогтоох, техникийн болон арилжааны зэргээр салгаж алдагдлын хэмжээг тогтоож байна.

“Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК

Нийт  
**3.28**  
хувь

Нийт

**3.28**  
хувь

Хэрэглэгч

**16.41**  
хувь

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

Нийт  
**4.65**  
хувь


Нийт

**4.65**  
хувь


Хэрэглэгч

**9.00**  
хувь


Дамжуулалт, түгээлтийн алдагдлын судалгаа, хувиар




Нэг хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх хугацаа, Исайди /цаг/



Нэг хэрэглэгчид ногдох тасалдлын тоо, Исайфи /тоо/





Тасарсан хэрэглэгчийн тасралтын дундаж хугацааны индекс, Икайди /минут/



Олон улсад мөрддөг Исайди, Исайфи, Икайди тооцдог болсон бөгөөд нэг хэрэглэгчид ногдох тасалдлын үргэлжлэх хугацаа **10** жилийн хугацаанд **6 дахин**, салбарын хэмжээнд нэг хэрэглэгчид тасалдлын давтамж **1.8 дахин**, тасралтын дундаж хугацааны индекс **3.6 дахин** тус тус буурсан байна.

# ЭХ ҮҮСВЭРИЙН СУУРИЛАГДСАН ХҮЧИН ЧАДАЛ





## 4 | Эрчим хүчний үнэ тарифын зохицуулалт

# ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФЫН ЗОХИЦУУЛАЛТ

**Тарифт өөрчлөлт оруулсан хувь хэмжээ**

**Төв, Зүүн бүс**

Цахилгаан: 9.5-12.5%  
Дулаан: 12.2%

**Төв, Зүүн, Өмнөд, АУ бүс**

Цахилгаан: 16.1-21.3%  
Дулаан: 15.2-17.2%

**Баруун бүс**

Цахилгаан: 38.0-68.4%

**Төв, Өмнөд бүс**

Цахилгаан: 5.5%




**Тарифын ангиллын өөрчлөлт**


**Хэрэглэгчийн тарифын зохицуулалтыг нийт 9 удаа хийсэн.**

# ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧНИЙ ТАРИФЫН ӨӨРЧЛӨЛТ


ААНБ-ын ЦЭХ-ний тариф, төг/кВт.ц




Айл өрхийн ЦЭХ-ний тариф, төг/кВт.ц



Улаанбаатар хотын ААНБ, айл өрхийн дулааны тариф



Улаанбаатар хотын ААНБ-ын дулааны тариф, төг/Гкал





# ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН АШИГ, АЛДАГДАЛ

ТЗЭ-дийн татварын дараах **ашиг, алдагдлын** судалгаа, сая төгрөг




## Тайлбар:


Эрчим хүчний салбар 7.5 тэрбум кВт.ц (Оюутолгойн 1.3 тэрбум кВт.ц импортыг тооцоогүй) цахилгаан хэрэглэж, үйл ажиллагааны 1.49 их наяд төгрөгийн зардалтай, 1.4 их наяд төгрөгийн борлуулалтын орлоготой, **92.0** тэрбум төгрөгийн алдагдал (СЭХ-ний эрчим хүчний эх үүсгүүрүүдийн ашиг ороогүй дүнгээр)-тай ажилласан.

# ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН ОРЛОГО, ЗАРДЛЫН ӨӨРЧЛӨЛТ


Эрчим хүчний ТЗЭ-дийн **үйл ажиллагааны орлогын** өөрчлөлт, тэрбум төгрөг




Эрчим хүчний ТЗЭ-дийн **үйл ажиллагааны зардлын** өөрчлөлт, тэрбум төгрөг



**СЭХ болон бусад эх үүсгүүрийн** төлбөрийн өөрчлөлт, тэрбум төгрөг




**Импортын ЦЭХ-ний** төлбөрийн өөрчлөлт, тэрбум төгрөг



Уурхайн нэрс	Уурхайнуудын нүүрсний борлуулалт, мян.тн				Эзлэх хувь
	2017 он	2018 он	2019 он	2020 он	
Багануур	4,039.2	4,255.6	4,110.5	<b>4,050.5</b>	53.2%
Шарын гол	909.4	1,083.9	1,128.5	<b>1,003.9</b>	13.2%
Шивээ-Овоо	2,020.3	1,964.9	2,009.8	<b>1,987.8</b>	26.1%
Адуунчулуун	526.4	533.6	568.7	<b>571.4</b>	7.5%
<b>Нийт</b>	<b>7,495.3</b>	<b>7,838.0</b>	<b>7,817.5</b>	<b>7,613.6</b>	

ДЦС-ууд	Нүүрсний хэрэглээ, мян.тн				Эзлэх хувь
	2017 он	2018 он	2019 он	2020 он	
ДЦС-4 ТӨХК	3,462.4	3,384.5	3,495.5	<b>3,583.1</b>	50.7%
ДЦС-3 ТӨХК	1,294.2	1,331.5	1,305.3	<b>1,340.6</b>	19.0%
ДЦС-2 ТӨХК	244.2	264.7	254.1	<b>227.4</b>	3.2%
ЭДЦС ТӨХК	323.8	326.5	290.1	<b>256.6</b>	3.6%
ЭҮДЦС		435.9	375.7	<b>346.7</b>	4.9%
ДДЦС ТӨХК	400.3	400.2	433.5	<b>438.9</b>	6.2%
БНДС ТӨХК	56.9	61.6	61.4	<b>64.8</b>	0.9%
НДС ТӨХК	31.2	34.8	43.1	<b>36.7</b>	0.5%
АДС ТӨХК	125.4	189.6	229.8	<b>250.2</b>	3.5%
ДБЭХС ТӨХК	500.5	465.0	531.4	<b>527.4</b>	7.5%
<b>Нийт</b>	<b>6,438.9</b>	<b>6,894.2</b>	<b>7,020.0</b>	<b>7,072.3</b>	

### Нүүрсний үнийн өөрчлөлт, төг/тн



### Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүч үйлдвэрлэхэд ашиглах түлшний үнийг:

- 2013 оны 8 дугаар сард “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-иудын нүүрсний үнийг **10.0 хувиар**,
- 2014 оны 12 дугаар сард “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын гол” ХК, “Адуунчулуун” ХК-иудын нүүрсний үнийг **13.3-16.6 хувиар**,
- 2016 онд “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК, “Шарын гол” ХК-иудын нүүрсний үнийг **7.8-21.7 хувиар**,
- 2018 онд “Багануур” ХК-ийн нүүрсний үнийг **6.8 хувиар**, “Шивээ-Овоо” ХК-ийн нүүрсний үнийг **9.5 хувиар**, “Шарын гол” ХК-ийн нүүрсний үнийг **5.5 хувиар** тус тус нэмэгдүүлэхээр хянасан болно.
- 2019 онд “Багануур” ХК-ийн нүүрсний үнийг **6.3 хувиар**, “Шивээ-Овоо” ХК-ийн нүүрсний үнийг **7.3 хувиар**, “Шарын гол” ХК-ийн нүүрсний үнийг **5.1 хувиар** нэмэгдүүлэхээр хянасан.
- 2020 оны 03 дугаар сард “Шарын гол” ХК-ийн нүүрсний үнийг **9.9 хувиар** нэмэгдүүлэхээр хянасан.



## 5 | Эрчим хүчний хэмнэлтийн бодлого, хэрэгжилт

# ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ, ХЭРЭГЖИЛТ

Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль  
2015 оны 11 сарын 26-нд УИХ-аар батлагдсан.


Төрийн байгууллага

Мэргэжлийн үйлчилгээ

Хэрэглэгч

АЛБАДЛАГА,  
УРАМШУУЛАЛ

- Төрийн бодлого, хууль;
- Дүрэм, журам;
- Норм, стандарт.



ЗОРИЛТОТ БҮЛЭГ

- Үүрэг хүлээсэн хэрэглэгч
  - Эрчим хүчний салбар
  - Аж үйлдвэрийн салбар
  - Барилгын салбар
- Бусад хэрэглэгч



## ЭРЧИМ ХҮЧ ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ХУУЛИАР

1

Эрчим хүч хэмнэлтийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг Улсын хэмжээнд зохион байгуулах, эрх зүйн зохицуулалтыг сайжруулах санал боловсруулах;

2

Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийг тодорхойлж бүртгэх, мэдээ тайлан авч, эрчим хүчийг хэмнэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг мэргэжлийн арга зүйгээр хангах;

3

Эрчим хүчний аудитор, Эрчим хүч хэмнэлтийн менежерийг бэлтгэх, мэргэшүүлэх, эрчим хүч хэмнэлтийн мэргэжлийн байгууллагуудад магадлан итгэмжлэл олгох;

4

Эрчим хүчийг хэмнэх, үр ашигтай хэрэглээний мэдээллийн систем хөгжүүлэх, нийтэд сурталчлах, танин мэдүүлэх ажлыг зохион байгуулах;

- Эрчим хүчний хэмнэлтийн хуультай 62 улс;
- Хэмнэлтийн бодлого, хөтөлбөртэй 51 улс;
- Эрчим хүчний хэмнэлтийн байгууллага 56 улс;
- Яам болон бусад байгууллагатай хамтарсан 75 улс.



### Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн тооцоогоор гарсан хэмнэлт:

2018 оны тайланд:

51.7 сая кВт.ц буюу  
8.5 тэрбум төгрөг

2019 оны тайланд:

67.7 сая кВт.ц буюу  
11.2 тэрбум төгрөг

2020 оны тайланд:

98.1 сая кВт.ц буюу  
16.2 тэрбум төгрөг

ҮХХ-ийн ангилал	Үүрэг хүлээсэн хэрэглэгчдийн тоо	Эрчим хүчний аудит				Эрчим хүч хэмнэлтийн менежер			
		хийлгэсэн	хийгдэж байгаа	хийлгээгүй	дараагийн аудит	томилсон	сурсан	мэргэжлийн	инженерийн алба
Барилга байгууламж	74	46	9	19	14	68	60	24	34
Эрчим хүч хэрэглэгч	89	48	9	32	14	81	80	73	44
Эрчим хүчний салбар	34	31	9	1	14	34	30	32	34
<b>Нийт</b>	<b>197</b>	<b>125</b>	<b>18</b>	<b>52</b>	<b>42</b>	<b>183</b>	<b>170</b>	<b>129</b>	<b>112</b>

Үүрэг хүлээсэн **197** хэрэглэгчдээс **183** нь буюу **93 хувь** эрчим хүч хэмнэлтийн менежерийг томилон ажиллаж байна.

Эдгээр байгууллагын **143** нь буюу **73 хувь** эрчим хүчний аудит хийлгэж, **11** байгууллага хоёр дахь шатны аудитыг хийлгэсэн бол **42** байгууллага 2022 онд хийлгэхээр төлөвлөж байна.





## 6 | Эрчим хүчний зохицуулах хорооны хөгжлийн стратеги



# ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДУНД ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН СТРАТЕГИ

## АЛСЫН ХАРАА:

Эрчим хүч хэрэглэгч, хангагчийн итгэл хүлээсэн, хөгжилд хөтлөх мэргэшсэн, манлайлагч байгууллага байна.


## ЭРХЭМ ЗОРИЛГО:

Монгол Улсын тогтвортой хөгжил, иргэдийн амьдралын чанарыг хангахад чиглэсэн эрчим хүчний **найдвартай, үр ашигтай, байгаль орчинд ээлтэй** технологи, үйл ажиллагааг дэмжсэн зохицуулалтын тогтолцоог төлөвшүүлнэ.

УРИА: Ухаалаг зохицуулалт – Хөгжлийн ирээдүй

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРЧМУУД:

1. Хараат бус байх
2. Хууль дээдлэх
3. Ил тод байх
4. Тэгш шударга байх
5. Хэрэглэгчийг дээдлэх
6. Мэргэшсэн байх



**Стратегийн зорилго 1:** Эрчим хүчний салбарыг зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн зарчмаар ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

**Стратегийн зорилго 2:** Эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааг зах зээлийн зарчимд нийцүүлэн үр дүнг чухалчилсан зохицуулалтаар хангах;

**Стратегийн зорилго 3:** Инноваци, дэвшилтэт техник, технологид суурилсан эрчим хүчний хангамж, хэрэглээний хэмнэлт, үр ашгийг нэмэгдүүлэх;

**Стратегийн зорилго 4:** Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоог нэвтрүүлэх;

**Стратегийн зорилго 5:** Мэдлэг чадварт суурилсан, мэргэшсэн, манлайлагч байгууллага болох;

Хороо нь чадварлаг, бүтээлч хамт олныг бий болгох, ажлын гүйцэтгэлийг сайжруулахад удирдлагын менежментийг хөгжлийн **Стратегийн 5 дахь зорилготой** уялдуулан дараах хэлбэрээр хэрэгжүүлж байна. Үүнд:

**1. Хорооны зорилго, чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэдлэг чадвар, мэргэшилд суурилсан хүний нөөцийг хөгжүүлэх;**



- ХБНГУ, БНСУ, БНХАУ, Австрали, АНУ зэрэг улсуудын их сургуулиудад Хорооны нийт 11 ажилтныг эрчим хүч, бизнесийн удирдлагын магистрантурт эдгээр улсын тэтгэлгээр сургаж байна.  
- Салбарын болон Хорооны өмнө тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ажилтнуудын мэргэшил, гадаад хэлний мэдлэг, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, бусад ур чадварыг хөгжүүлэхэд онцгойлон анхаарч байна.

**2. Хорооны дотоод үйл ажиллагааг цахимжуулах, түргэн шуурхай байдлыг хангах;**



Хорооны хурлын дотоод систем <https://is2.erc.mn/>  
Хорооны цахим хурлын онлайн систем <https://meeting.erc.mn>  
Тусгай зөвшөөрлийн цахим систем <http://license.erc.mn/>  
Эрчим хүч хэмнэлт, аудитын систем <http://ecc.erc.gov.mn/>  
Хэрэглэгчдийн цахим лавлах <https://info.erc.mn/>  
Дотоод мэдээллийн болон албан хэрэг хөтлөлтийн систем <https://able.mn/>  
Хорооны мэдээллийн веб сайт <http://erc.gov.mn>





Эрчим хүчний зохицуулах хороог бие даасан үйл ажиллагаа явуулах, тусгай зөвшөөрөл, үнэ тариф, цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ болон эрчим хүч хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



**ХАМТЫН АЖИЛЛАГААТАЙ БУСАД  
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА,  
ХӨТӨЛБӨРҮҮД**

## Эх үүсвэр

### Шинээр барих эх үүсвэр

1. Багануурын ДЦС (400 МВт)
2. Эрдэнэбүрэнгийн УЦС (92 МВт)
3. Тавантолгойн станц (450 МВт)  
Хөрөнгө оруулалт - 566 сая \$


### Өртгөтгөл

1. Чойбалсангийн ДЦС (50 МВт)
2. Амгалан дулааны станц (50 МВт)  
Хөрөнгө оруулалт - 47 сая \$
3. Дулааны III цахилгаан станц (75 МВт)  
Хөрөнгө оруулалт - 90 сая \$
4. Дулааны IV цахилгаан станцад шинэ зуух барих (500 тн/цаг)  
Хөрөнгө оруулалт - 72 сая \$

Нийт 774.6 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байна.



## Шинээр барих цахилгаан дамжуулах шугам сүлжээ



# ЦААШДЫН ЗОРИЛТ

1

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”, “Төрөөс эрчим хүчний талаар баримлах бодлого”-ын хүрээнд зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээл дээр суурилсан, үр ашигтай, хэмнэлттэй, ногоон хөгжлийг дэмжсэн, ухаалаг технологи бүхий эрчим хүчний салбарыг хөгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

2

Бодит өртөг, ашгийн зохих түвшинг хангасан хэрэглэгчийн үнэ тарифын тогтолцоог бүрдүүлэх, индексжүүлэлтийг хэрэгжүүлэх замаар эрчим хүчний салбарын санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг хангах;

3

Урамшуулалт зохицуулалтын зарчимд үндэслэн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дунд болон урт хугацаанд мөрдөх үнэ тарифыг аргачлалыг хэрэгжүүлэх;

4

Цахилгаан түгээх сүлжээний хангах үйл ажиллагаанд “Ухаалаг систем”-ийг нэвтрүүлж, үр ашгийг дээшлүүлэх, өртөг зардлыг бууруулах, найдвартай ажиллагааг хангахад үнэ тарифын бодлогоор дэмжих;

5

Эрчим хүчний зохицуулах хорооны зохицуулалтын үйл ажиллагааг ил тод, шуурхай болгох зорилгоор цахимжуулах;

6

Эрчим хүчний салбарын компаниудын засаглалыг сайжруулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стратеги, удирдлагын шинэ менежментийн арга хэрэгслийг нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

# ЦААШДЫН ЗОРИЛТ

7

Эрчим хүчний салбарын компаниудын бүтэц, зохион байгуулалт, орон тооны хязгаарыг норм, нормативд үндэслэн борлуулалтын орлогын шаардагдах хэмжээнд тооцох;

8

Аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдийг бие даасан, хараат бус байдлаар ажиллуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

9

Эрчим хүчний хэмнэлтийг дэмжсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, ЭСКо зах зээлийг хөгжих нөхцөлийг бүрдүүлэх;

10

Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж барих, машин, тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүн, материал үйлдвэрлэх, импортлох болон эрчим хүчний үр ашгийг дээшлүүлж хэмнэлт гаргасан иргэн аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, урамшуулал олгох тогтолцоог хэрэгжүүлэх;

11

Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах механизмыг хэрэгжүүлэх замаар стандартын бодлогоор эрчим хүчний эцсийн хэрэглэгч дээрх үр ашгийг сайжруулах;

12

Монгол Улсын эрчим хүчний салбарыг хөгжлийн шинэ шатанд гаргахын тулд шинээр эх үүсвэрүүдийг нэн яаралтай барьж, өсөн нэмэгдэж буй дотоодын хэрэглээг бүрэн ханган эрчим хүч экспортолдог болоход гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжсэн, тэдгээрийн сонирхлыг татахуйц зохицуулалтын бодлого баримтлах;



**АНХААРАЛ  
ХАНДУУЛСАНД  
БАЯРЛАЛАА**